



САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Х.ГАНЦОГТ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.02.25 № 01/02 УАТ-ГАТ/2013/01-СМА-ТМН/3

Зөрчил арилгах тухай

Сангийн яамны аппаратын 2012 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Засгийн газрын цом” болон салбарын хэмжээний уралдаан тэмцээнд амжилт гаргасан нэр бүхий 23 ажилтныг 8.3 сая төгрөгөөр шагнасан, шинэ жилийн арга хэмжээнд буюу клип, дуу бичлэг, хоолны зардлын 13.1 сая төгрөг, нийт 21.4 сая төгрөгийн зардлыг тус байгууллагаас санхүүжүүлсэн зөрчил илэрсэн нь Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 13.2 “Улсын төсвийн байгууллага батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

“Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12 дугаар заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1 дүгээр заалтыг үндэслэн дээрх алдаа, зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт, ерөнхий нягтлан бодогч Б.Тамир нарт нарт үүрэг болгож, албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг 2013 оны 06 дугаар сарын 25 -ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР



Ч.БОЛД

070004